switchasia
Funded by the European Union

FONDATION Abbé Pierre

GLOBAL ALLIANCE FOR GREEN AND GENDER ACTION

AFD



ТУРШЛАГА

ДУЛААН ШИЙДЭЛ
SWITCH OFF AIR POLLUTION

ХЯЛБАР ШИЙДЭЛ АЯН

Хэрэгжүүлэгч байгууллагууд

geres ACTING FOR CLIMATE SOLIDARITY

BEEC

MNCA

MGFC

МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САН

Агуулга

1 ХЯЛБАР ШИЙДЭЛ АЯН

- Гарын авлага хэнд зориулагдсан бэ 1
- Хялбар шийдэл аян гэж юу вэ 1
- Хялбар шийдэл аяны ач холбогдол

2 ХЯЛБАР ШИЙДЭЛ АЯНЫГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛАХ ВЭ

- Орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах
- Дүүргийн оролцоо
- Хороо, иргэний нийгмийн байгууллагын оролцоо
- Хороо сонгон шалгаруулах
- Иргэний нийгмийн байгууллага сонгон шалгаруулах

3 ОЛОН НИЙТИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

- Сургагч багш
- Сайн дурын идэвхтэн
- Сургалтын тайлан бичих






Энэхүү гарын авлагыг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр гаргав. Дурдагдсан аливаа мэдээллийн үнэн зөв байдлыг “Дулаан шийдэл 2” төсөл бүрэн хариуцах бөгөөд Европын Холбооны байр суурийг илэрхийлээгүй болно.

4

СУРГАГЧ ӨРХТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ

- **Сургагч өрхүүд хөршдөө мэдээлэл хүргэх**
- **Сошиалаар олон нийтэд мэдээлэл хүргэх**



ХАВСРАЛТУУД

- Санамж бичиг
- Хороо сонгох шалгуур
- Иргэний нийгмийн байгууллага сонгон шалгаруулах
- Сургалтын хөтөлбөр
- Сургалтын ПЛТ
- Олон нийтийн сургалт бүртгэл хуудас
- Тайлангийн загвар
- Сургагч өрхийн бүртгэл хуудас загвар



1 БҮЛЭГ Хялбар шийдэл аян

Гарын авлага хэнд зориулагдсан вэ?

Энэхүү гарын авлагыг Хялбар шийдэл аяныг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа байгууллага, иргэний нийгмийн байгууллага хамт олонд зориулсан юм. Гарын авлагыг аяныг хэрэгжүүлэх явцад цуглуулсан сургамж мэдээлэл дээр үндэслэн бэлтгэлээ. Хялбар шийдэл аяныг хэрхэн ямар дарааллаар, ямар оролцогч талуудыг оролцуулбал үр дүнтэй хэрэгжиж болох талаар мэдээллүүдийг багтаасан юм. Олон нийтэд дулаалгын талаарх мэдээлэл хүргэж, гарын дор материалаар дулаалга хийх, тав тух, хэмнэлтийг бий болгоно гэдэг мэдээллийг хүргэхээр Хялбар шийдэл аяныг санаачлан хэрэгжүүлсэн билээ.

Хялбар шийдэл аян нь олон нийтэд байшин сууцаа дулаалах сэдэл төрүүлэх алхам алхмаар байшингаа дулаалж стандарт бүрэн дулаалга хийлгэх сэдэл төрүүлэх ингэснээр эрчим хүчний хэмнэлт бий болгоно гэдэг агуулгатай бөгөөд энэхүү үйл ажиллагаанд бүх талуудыг оролцуулсан нь мөн томоохон амжилт болсон юм. Жил бүрийн сургамж туршлага дээрээ суурилан сайжруулсаар ирсэн бөгөөд олон нийтийн хэрэгцээ шаардлага дээр үндэслэн сургалт үйл ажиллагаа баяжуулсан.

Мөн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аяныг хэрэгжүүлэхэд дүүрэг, орон нутгийн засаг захиргааны байгууллагыг оролцуулж хэрэгжүүлсэн. Ингэснээр төрийн болон иргэний нийгмийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа сайжирсан.

Дүүргүүд өөрсдийн жилийн ажлын төлөвлөгөөнд агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн үйл ажиллагаанд Хялбар шийдэл аяны үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулж олон нийтэд мэдээлэл хүргэж ажиллаж байлаа.

Жишээ нь: Баянзүрх дүүргийн агаар орчны бохирдлын тасаг нь өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд хороод дээр өдөрлөг зохион байгуулсан юм. Энэхүү өдөрлөгт гэр хорооллын айл өрхүүдэд элбэг тохиолддог бэрхшээлүүд болох хөрсний бохирдолыг бууруулах, ариун цэврийн байгууламжийг сайжруулах талаар, угаарын хийн хордлогоос хэрхэн урьдчилан сэргийлэх, агаарын бохирдлыг бууруулхад хувь нэмэр оруулах зорилгоор байшин сууцыг хэрхэн дулаалах, дулаан алдагдлыг хэрхэн бууруулах, хялбар аргаар хаалга цонх, шал, хана хэрхэн дулаалах талаар мэдээлэл хамтарсан өдөрлөг зохион байгуулсан юм. Энэхүү өдөрлөг нь хороон дээр, олон нийтийн дунд зохион байгуулагдсан тул иргэдийн оролцоо сайтай үйл ажиллагаа болсон юм.

Дүүргүүд хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагаа өдөрлөг, олон нийтэд суурилсан үйл ажиллагаа иргэдийн оролцоо сайтай байх нь зарим тохиолдолд хариуцсан ажилтнаас шалтгаалах тохиолдол бас байдаг. Хариуцсан ажилтанд өөрсдийн зүгээс зохион байгуулж байгаа үйл ажиллагаа, төлөвлөгөө зэргийг хуваалцаж, цаг үеийн мэдээлэл өгч харилцан уялдаа холбоотой ажиллах хэрэгтэй. Мөн зохион байгуулахаар төлөвлөсөн ажлыг дүүргийн жилийн, улирлын үйл ажиллаганы төлөвлөгөөнд багтсан ажилтай уялдуулан хамтран ажиллах нь үр дүнтэй болж байлаа.



Хялбар шийдэл аян гэж юу вэ?

Дулаан шийдэл төслийн үйл ажиллагааны хүрээнд “Хялбар шийдэл” аяныг Улаанбаатар хотын гэр хорооллын хувийн байшин сууцыг дулаалж, дулаан алдагдлыг багасгаж, агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулахад иргэдийн оролцоо, ялангуяа эмэгтэйчүүдийн манлайллыг нэмэгдүүлж, дулаалгын ач холбогдлын талаар олон нийтийн ойлголт, хандлагыг сайжруулахыг уриалах зорилготойгоор зохион байгуулсан. 2018-2024 онд Улаанбаатар хотын Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх дүүргүүдэд сонгогдсон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүллээ. Дулаан шийдэл төсөл нь олон нийтэд дулаалгын ач холбогдлыг таниулан , иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс **“Хялбар шийдэл”** олон нийтэд мэдээлэл олгох аяныг хэрэгжүүлсэн.

Дулаан шийдэл I (2018-2022) төслийн хүрээнд нийт

674 өрхийг дулаалгын сургалтад хамруулж

18,200 орчим хүнд биет болон биет бус байдлаар мэдээлэл хүргэж ажилласан ба үүнээс

1,429 өрх байшиндаа хялбар дулаалга хийж,

274 өрхөд төслийн зүгээс 5см дээврийн дулаалга хийж амжилттай ажилласан байна.





Дулаан шийдэл II (2022-2026)

төсөл хэрэгжсэн эхний 2 жилийн хугацаанд бид


943 өрхийг дулаалгын сургалтад хамруулж

60,000 орчим хүнд биет болон биет бус байдлаар мэдээлэл хүргэж ажилласан

1,445 өрх байшиндаа хялбар дулаалга хийж,

249 өрхөд төслийн зүгээс 5см дээврийн дулаалга хийж өгсөн байна.

Төслийн үйл ажиллагааны хүрээнд Хялбар шийдэл аяныг нийслэлийн Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх дүүргүүд дүүрэг тус бүрд таван хороо нийт тавин хороонд амжилттай хэрэгжүүлсэн.





Дулаан алдагдлыг бууруулах замаар агаарын бохирдлыг бууруулах ач холбогдлыг олон нийтэд таниулах алхам алхмаар байшин сууцандаа дулаалга хийлгэх сонирхолыг төрүүлэх, олон нийтийг идэвхжүүлэх зорилгоор Хялбар шийдлийг боловсруулж олон нийтэд сурталчилсан.

Төслийг зах зээлд суурилсан үйл ажиллагааг дэмжих зорилгоор төслийг хамтран хэрэгжүүлэгч нартай Хялбар шийдэл аяныг зохион байгуулсан.

Хялбар шийдэл аяны ач холбогдол

Хялбар шийдэл аян нь гэр хорооллын айл өрхийн байшин сууцны дулаан алдагдлыг бууруулж, дулаалснаар түлшний хэрэглээ багасаж, хэмнэлт бий болгох зорилгоор олон нийтийг идэвхжүүлэх мэдээ мэдээлэл хүргэх, мэдлэг олгох ач холбогдолтой юм.

Хялбар шийдлүүд нь айл өрхүүд гарын дор олдоц сайтай материал ашиглан байшин сууцаа дулаалж тав тухтай орчныг бүрдүүлж, хэмнэлтийг бий болгох зорилготой. Иргэд олон нийтэд шалгагдаж туршигдсан шийдлүүдийг боловсруулан хүргэх нь хамтран хэрэгжүүлэгч нарын зорилго байлаа. Барилгын хэмнэлтийн төв өөрсдийн үйл ажиллагааны хүрээнд хаалга, цонх, хана, дээвэр, яндан хоолой зэрэг дулаан алдагдал их байдаг хэсгүүдэд тохирох

шийдлүүдийг боловсруулан, санал болгосон. Эдгээр санал болгосон аргууд нь бүгд туршигдсан бөгөөд хэдий хэмжээний хэмнэлт бий болгож байгааг ч мөн тооцоолон гаргасан юм. Мөн дараа нь Хялбар дулаалга хийх аргууд нь олдоц сайтай материалтай байх нь илүү хүртээмж гэж үзсэн.

Хялбар шийдлүүдийг байшин сууцаа дулаалдхад хэрэглэх нь дараах ач холбогдолтой. Үүнд:

- Гарын дор олдоц сайтай материал ашиглана.
- Үр дүн нь шууд мэдрэгдэнэ
- Түлшний хэрэглээ багсана
- Та тухтай орчин эрүүл мэндэд аргээр нөлөөлнө.
- Хэмнэлт бий болгоно
- Галлах, үнс тоос гаргах зэрэгт зарцуулдаг цаг багсана.
- Хэрэгжүүлэхэд хялбар гарууд тул өөрсдийн санааг нэмж баяжуулах боломжтой юм.

Бидний боловсруулсан арга нь бүх өрхүүдийн байшин сууцад тохирох боломжтой байхаар тооцоолсон юм.

Үүний тулд төслийн хамтран хэрэгжүүлэгч Барилгын эрчим хүч хэмнэлтийн төвтэй хамтран тохирсон шийдлүүдийг боловсруулсан. Эдгээр шийдлүүд нь байшин сууцны хана, цонх, дээвэр, хаалга, шал, яндан хоолой зэрэг хэсгүүдэд гарын доорх материал ашиглаж хэрхэн дулаалга хийх боломжтой талаар юм.

Улаанбаатар хотын агаарын бохирдлын бий болгож, тоос тоосонцрын хэмжээг нэмэгдүүлж байгаа түлшний хэрэглээг бууруулж, агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулах боломжтой юм.

> ***СЭТГЭГДЭЛ: / Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны 12-р гудамж-12-163 тоот иргэн Хувцагааны Болормаа/***
>
> *Манай байшин 50мкв талбайтай, Хялбар шийдлийн дулаалгын аргаар цонх, яндан, хаалгаа дулаалсан. Дулаалгын үр дүн илт мэдрэгдсэн. Гэр дулаахан болохоор их тухтай, цэвэрлэгээ хийхэд урамтай, цэвэрхэн тохилог байх талаасаа их ахиц гарсан.*

Төслийн үйл ажиллагааны хүрээнд " Дулаалгын хөтөлбөрт хамрагдсан төлөөлөгч өрхүүдийн нийгэм эдийн засагт үзүүлсэн нөлөөллийн судалгаа" –нд гэртээ гал түлэх ажлыг хэн нэгэн нь эхнэрүүд гал түлэх ажлыг хариуцан хийдэг. Байшин сууц дулаан байх галлах хүүхдүүд, гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийн талаарх бүх асуудлыг өрх гэрийн эзэгтэй, эмэгтэйчүүд хариуцах нь цөөнгүй байдаг.

Ийм учир дулаан алдагдлыг бууруулах, дулаалга хийх, эрүүл тав тухтай орчинд амьдрах шийдвэр гаргалт, хэрэгжилтэд эмэгтэйчүүдийн манлайлал чухал үүрэгтэй байдаг нь байна.

Гал түлэх тоо цөөрснөөр эмэгтэйчүүдийн хөдөлмөр хөнгөвчлөгдсөн байна. Үүнийг дагаад өөртөө болон гэр бүлдээ зарцуулдаг цаг нэмэгдсэн байдаг.

бүлэг 2

Хялбар шийдэл аяныг хэрхэн хэрэгжүүлэх вэ?



Орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах

Хялбар шийдэл аяныг хэрэгжүүлэхээр сонгогдсон дүүргийн удирдлагад төслийн зүгээс хамтран ажиллах саналыг албан бичгээр илгээнэ.

Уулзалтад оролцох талууд харилцан тохиролцсоны дагуу албан ёсны танилцах уулзалт зохион байгуулна. Уулзалтаар талууд харилцан мэдээлэл солилцоно:

- Төслийн үйл ажиллагааны танилцуулах
- Хялбар шийдэл аяны талаар мэдээлэл өгөх
- Бусад дүүргүүдэд Хялбар шийдэл аяныг хэрхэн хэрэгжүүлсэн талаарх мэдээлэл
- Дүүргийн зүгээс ямар дэмжлэг туслалцаа шаардлагатай талаар дурдах зэрэг харилцан ярилцана.

Дүүрэгтэй хамтын ажиллагааны хүрээнд санамж бичиг байгуулахын зэрэгцээ хариуцан ажиллах албан тушаалтныг томилон үүрэгжүүлдэг.

Хамтран ажиллах санамж бичгийн төсөл хувилбарыг хариуцан талууд хэлэлцэж эцэслэсний дараа гарын үсэг зурж баталгаажуулна. Санамж бичиг нь дараах мэдээллүүдийг заавал батгаасан байх шаардлагатай байдаг. Үүнд:

- Уулзалтаар төслийн үйл ажиллагаа, санхүүжүүлэгчид, хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд, нийлүүлэгчид гээд төслийн хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар мэдээлэл
- Талуудын оролцоо, хамтын ажиллагаа
- Санамж бичигт өдөр тутмын үйл ажиллагаа мэдээ мэдээлэл, тайлан хүргүүлж , холбоотой ажиллаж байх хариуцсан ажилтныг томилж өгөх талаар дурдан оруулсан байна.
- Хамтарсан өдөрлөг үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах
- Хороог хэрхэн чиглүүлэн ажиллах талаар багтаасан байна.

Дүүргийн оролцоо:

Хялбар шийдэл аяныг хэрэгжүүлэхэд дүүрэг орон нутгийн захиргааны хамтын ажиллагаа дэмжлэг шаардлагатай байдаг. Төслийн хүрээнд Хялбар шийдэл аяныг хэрэгжүүлэхээр сонгогдсон дүүрэгтэй хамтын ажиллагаа, хороодын идэвх оролцооны талаар дэлгэрэнгүй тусгасан санамж бичиг байгуулах нь аяныг үр дүнтэй хэрэгжихэд чухал түлхэц болдог. Дүүрэг нь:

- Орон нутгийн захиргаа нь хороодыг чиглүүлэх, үүрэгжүүлэх өөрсдийн үйл ажиллагаатай уялдуулан дулаалгын ач холбогдол, дулаан алдагдлыг бууруулах чиглэлээр өдөрлөг зохион байгуулах зэрэг дэмжлэг үзүүлдэг
- Дүүргийн зүгээс хамтран ажиллах санамж бичгийн дагуу хариуцан ажиллах хүнийг томилдог
- Хариуцсан ажилтанд аяны хэрэгжилт, үйл явцын талаар мэдээлэл өгч ажилласнаар оролцоог нэмэгдүүлдэг
- Аян хэрэгжихээр сонгогдсон хороодын оролцоог нэмэгдүүлж, чиглүүлж, үүрэгжүүлж өгдөг.

Дүүргийн зүгээс хамтын ажиллагааны санамж зүгт тусгасны дагуу хариуцан ажиллах хүнийг томилсноор хамтын ажиллагаа илүү нэмэгддэг. Тухайн ажилтанд аяны хэрэгжилт, явц, үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч хамтран ажилласнаар дүүргийн удирдлагууд аяны талаарх мэдээллийг цаг тухай бүрд нь авдаг. Энэ нь хамтран хэрэгжүүлж буй үйл ажиллагаа тул цаашдын үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулж болох талаарх дараагийн алхмуудыг төлөвлөхөд дөхөм болдог. Дүүргийн зүгээс хороодод аяны талаар мэдээлэл өгч идэвхи санаачилгатай хамтран ажиллах үүрэг өгснөөр оролцоо нэмэгддэг.



> ***Баянзүрх дүүргийн АОБТ-н дарга М.Бат-Эрдэнэ:*** *Дулаан шийдэл төсөл Хялбар шийдэл аяны хүрээнд бид хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Үйл ажиллагааны хүрээнд агаарын бохирдол, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бусад Төрийн бус байгууллагуудтай хамтарсан өдөрлөг, сургалт зохион байгуулсан. Дүүрэгт үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирсан гэж хэрж байна. Иргэд энэ чиглэлийн мэдээлэл авах хэрэгцээ их байгаа талаар хорооллын хэсгийн ахлагч нар бидэнд ирүүлж байна.*



Хороо, иргэний нийгмийн байгууллагын оролцоо

Хорооны оролцоо:

Хороо нь олон нийт, айл өрхүүдийг идэвхжүүлэх, өөрсдийн сошиал хуудас, хэсгийн ахлагч нараар дамжуулан мэдээ мэдээлэл хүргэх үүрэгтэйгээр аяныг хэрэгжүүлэхэд оролцдог. Хороог түшиглэн олон нийтийн сургалтыг зохион байгуулна.

- Олон нийтийн сургалт зохион байгуулахад өрөө танхим гаргаж өгөх
- Иргэдэд олон нийтийн сургалтын талаар мэдээлэл хүргэх
- Шаардлагатай статистик тоон мэдээллийг гаргаж өгөх
- Хэсгийн ахлагч нарт аян хэрэгжих талаар мэдээлэл өгч үүрэгжүүлэх
- Шаардлагатай тохиолдолд нээлттэй хаалганы өдөр, өдөрлөг зохион байгуулахад хамтран ажиллах зэрэг үүрэгтэй оролцдог.

> ***Э.Энхтөгс Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны Засаг дарга:*** *Манай хороо нь 96.72га газартай, 1952 өрхтэй. Уг төсөлд манай хорооноос өрх сонгогдож, хамрагдсанд маш их баяртай байгаа. Бидний хамтын ажил маш үр дүнтэй болсон гэж дүгнэж байна. Хорооны зүгээс ажилчид мөн төслийн сургалтад хамрагдаж, дан ганц сургагч багш, сайн дурын идэвхтнээс гадна бүх хэсгийн ахлагч нар олон, өрхөд төслийн мэдээллийг, дулаалгын аргыг хэлж зааж өгч, цахим орчинд мөн мэдээллийг хүргэж ажилласан. Уг төсөлд хамрагдах хүсэлтэй, эрэг сэтгэгдэлтэй өрхүүд маш олон байна. Хамтран ажиллахад таатай байлаа.*

Хороо нь засаг захиргааны хамгийн анхны нэгж учир иргэдэд мэдээлэл хүргэх, оролцоог нэмэгдүүлэхэд хамгийн тохиромжтой. Хорооны засаг дарга хэсгийн ахлагч нарыг үүрэгжүүлэн ажиллах нь олон нийтийн сургалт амжилттай зохион байгуулагдахад томоохон түлхэц болдог. Хялбар шийдэл аяны талаарх мэдээллийг иргэд олон нийт засаг захиргааны нэгж болох хороо, хэсгийн ахлагчаар дамжуулан авснаар оролцоо нэмэгддэг. Мөн иргэд хороо захиргаа нь баталгаатай мэдээллийг дамжуулдаг гэсэн итгэл үнэмшилтэй байдаг тул оролцоо нь сайжирч өөрт хэрэгцээтэй мэдээллийг хороогоор дамжуулан авах сонирхолтой байдаг байна.

Иргэний нийгмийн байгууллагын оролцоо:

Аян хэрэгжүүлэхэд тухайн дүүрэгт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагын оролцоо их байдаг. Иргэний нийгмийн байгууллага нь Сургагч багш сайн, дурын идэвхтэнтэй хамтран хороон дээр олон нийтийн сургалт зохион байгуулдаг. Аяны үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад сургагч багш, сайн дурын идэвхтний зохион байгуулалтыг хариуцан ажиллана. Иргэний нийгмийн байгууллага нь

- Сонгогдсон хороон дээр олон нийтийн сургалт зохион байгуулах
- Хороо хэсгийн ахлагч нарын мэдээ мэдээллээр хангах
- Хялбар шийдэл аяны талаар сурталчилах,
- Сайн дурын идэвхтнүүдийг сургаж бэлтгэх, дадлагажуулах
- Сургагч өрхийн таван хөршийн мэдээлэл, бүртгэл, зургаар баталгаажуулах үйл ажиллагааг хариуцах
- Дүүргийн захиргаа, хариуцсан ажилтанд аяны хэрэгжилтийн талаар мэдээлэл хүргэх
- Аяны талаарх тараах материал, гарын авлага зэргийг олон нийтэд хүргэх
- Өдөрлөг олон нийтийн үйл ажиллагаагаар олон нийтэд аяны талаарх мэдээллийг хүргэх зэргээр хамтран ажилладаг.

> ***Чингэлтэй дүүргийн Улаан Загалмайн хорооны дарга Н.Ганчимэг:*** *Дулаан шийдэл төслийн хүрээнд хэрэгжүүлсэн Хялбар шийдэл аяны зорилго, үр дүн их тодорхой байлаа. Манай Улаан Загалмайн Дунд Шатны Хорооны хувьд уг аяны хүрээнд сайн дурын идэвхтэн, иргэд, төрийн байгууллагатай хамтран ажиллах уялдаа холбоог нэмэгдүүлээд зогсохгүй аяны үр дүн өөрөө нүдэнд харагдахуйц иргэдийн амьдралд маш үр өгөөжтэй байж, тэдний талархлыг их хүртсэн нь эерэг, урамтай байлаа. Аяны ажил, заавар их тодорхой, төслийн баг хамт олны хандлага, харилцаа эерэг, чөлөөтэй байсан нь хамтарч ажиллахад таатай байлаа. Цаашид зөвхөн төслийн хугацаанд гэлтгүй гэр, байшин сууцыг дулаалах стандарт болон хялбар аргын талаар иргэдэд сургалт, зөвлөмжийг хүргэж, үр ашгийн талаар мэдээллийг өгч байх юм.*

Иргэний нийгмийн байгууллагын оролцоо нь өрхүүдийг идэвхжүүлэх мэдээлэл хүргэх гол зорилго бүхий бөгөөд айл өрхүүдэд хүрч ажиллах боломжтой байх шаардлагатай. Хялбар шийдлүүдийг хэрэгжүүлсэн айл өрхүүдийг бүртгэлжүүлэн, мэдээлэл хүргэх, зургаар баталгаажуулах үйл ажиллагаа нь сайн дурын идэвхтний дэмжлэгтэйгээр иргэний нийгмийн байгууллага хариуцан зохион байгуулдаг үйл ажиллагаа бөгөөд энэ нь аяны хэрэгжилтэд чухал хэрэгцээтэй мэдээлэл байдаг тул хариуцлагатай үйл ажиллагаа юм.

Хороо сонгон шалгаруулалт

Хялбар шийдэл аяныг хэрэгжүүлэхээр сонгогдсон хороодыг удирдан чиглүүлж арга зүйгээр хангаж ажиллах хэрэгтэй. Шаардлагатай тохиолдолд аяныг хэрэгжүүлэхээр сонгогдсон хороодын дарга нар, хэсгийн ахлагч нарт урьдчилан танилцуулга уулзалт сургалт зохион байгуулж болно. Аян хэрэгжүүлэх хороог шалгуур үзүүлэлтийн дагуу сонгон шалгаруулна.

ХОРОО СОНГОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

1. Гэр хорооллын эзлэх хувь
2. Байшинтай өрхий эзлэх хувь
3. Хүн амын тоо, зорилтот өрхийн тоо
4. Сонгогдох хороод хоорондоо ойрхон байх буюу сонгогдсон хороод нэг бүсэд байрлах

Хялбар шийдлүүдийг байшин сууцад хэрэгжүүлэх боломжтой тул тухайн дүүргийн гэр хороолол эзлэх хувийг ихэвчлэн харгалзан үздэг. Байшин сууцтай өрхийн тоог харгалзан үзэж, хороог сонгох нь олон нийтийн сургалтыг үр дүнтэй зохион байгуулахад нөлөөлдөг. Олон нийтийн сургалтыг зохион байгуулахад хорооны зүгээс өрхүүдэд мэдээлэл хүргэх, сургалтыг талаар зар тараах, сургалтын танхим зэрэгт дэмжлэг үзүүлдэг. Хороо нь өрхийн судалгаа мэдээлэл гаргах зэрэгт дэмжлэг үзүүлж ажилладаг. Шаардлагатай тохиолдолд

- Хорооны дарга, хэсгийн ахлагч нарт төслийн үйл ажиллагаа аяны талаар урьдчилан мэдээлэл өгөх сургалт зохион байгуулах
- Хэсгийн ахлагч нарыг нэгдсэн удирдлагаар хангах
- Хорооны сошиал хуудсаар дамжуулан хорооны иргэдэд мэдээлэл хүргэх
- Олон нийтийн сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах

Дүүрэгтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулсны дараа хороодын дарга нарт төслийн үйл ажиллагааг танилцуулах сургалт уулзалтууд зохион байгуулагдаж байсан юм. Энэхүү үйл ажиллагаа нь тухайн дүүргийн хороодын дарга нар, хэсгийн ахлагч нар, ажилтнуудад Хялбар шийдэл аяны талаар мэдлэг мэдээлэл олгохоос гадна хороог сонгон шалгаруулах үйл ажиллагаанд дөхөм байлаа.

Дүүргийн удирдлага хариуцсан ажилтнуудын зүгээс шалгуур үзүүлэлтэд нийцэж буй хороодыг санал болгох тохиолдлууд байв. Аяны үйл ажиллагаа хэрхэн явагдах, олон нийтийн оролцоо идэвхи ямар түвшинд байх нь хорооны удирдлага, ажилтнуудын санаачилга дэмжлэгээс ихээхэн шалтгаалдаг.

Аяныг хэрэгжүүлэхээр сонгогдсон хороо нь олон нийтийн сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажилладаг. Хорооны удирдлага ажилтнууд нь өрхүүдээ мэдлэг, мэдээллийг хүргэх, сургалтын талаар зар тараах өөрсдийн сувагтай гэх мэт олон давуу талтай бөгөөд сургалт зохион байгуулах танхим байраар дэмжиж ажилладаг.

Иргэний нийгмийн байгууллага сонгон шалгаруулах

Төслийн үйл ажиллагааны хүрээнд Хялбар шийдэл аяныг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн оролцоо зайлшгүй шаардлагатай.

- Тухайн дүүрэг, орон нутагт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагыг сонгон шалгаруулан аяны хэрэгжүүлэх бэлтгэл байдлыг хангаж эхэлдэг.
- Сонгон шалгаруулалтыг 1 сарын хугацаатай зарлах бөгөөд сонирхсон иргэний нийгмийн байгууллагууд оролцох талаар мэдээлэл авч болох бүхий л сувгаар зарлал мэдээг хүргэдэг.
- Иргэний нийгмийн байгууллага нь аяны хэрэгжилтийн явцад сургагч багш, сайн дурын идэвхтнүүдийг удирдлага арга зүйгээр хангаж ажиллахаас гадна хороо дүүрэгтэй хамтран олон нийтийн сургалт зохион байгуулах, айл өрхүүдэд сайн дурын идэвхтнүүдээр дамжуулан мэдээлэл хүргэх, хөршүүдийн зурган мэдээлэл тайлан нэгтгэн илгээх зэрэг үйл ажиллагааг хариуцан ажилладаг.
- Тогтвор сууршлтай бэлтгэгдсэн сайн дурын идэвхтнүүдтэй байх нь
- Гэр хорооллын айл өрхүүдэд мэдээлэл хүргэх чадвартай

Аяны хэрэгжилтийн явцад мөн аян хэрэгжиж дууссаны дараа иргэний нийгмийн байгууллага нь бэлтгэгдсэн сургагч багш болон сайн дурын идэвхтнүүдээр дамжуулан дулаалга, дулаан алдагдлын талаар иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэж хялбар аргуудыг ашиглан дулаан алдагдлаа бууруулж хэмнэлт бий болгох айл өрхүүдийн тоог нэмэгдүүлж ажиллах юм.

Саналаа ирүүлсэн иргэний нийгмийн байгууллагуудын хүсэлтээс шалгуур үзүүлэлтийн дагуу сонгон шалгаруулалтыг хийнэ.

Сонгогдсон иргэний нийгмийн байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулан цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөг хүлээн авч үйл ажиллагааг эхлүүлнэ.

БҮЛЭГ 3

Олон нийтийн сургалт зохион байгуулах



Хорооны удирдлага ажилчидтай харилцан тохиролцож сургалт зохион байгуулах өдрийг товлоно. Сургалт зохион байгуулагдахаас 10 өдрийн өмнөөс сургалтын талаар зар тараана. Хороо өөрийн пэйж хуудас болон олон нийттэй мэдээллээ хуваалцдаг сувгаар сургалтын талаарх мэдээллийг хүргэвэл илүү үр дүнтэй болно. Хорооны албан хаагчид, хэсгийн ахлагч нар ихэвчлэн иргэдийнхээ талаарх мэдээллийг мэдэж байдаг тул ямар өрхийг энэхүү сургалтад хамрагдуулж болох талаараа төлөвлөн мөн утсаар болно биеэр мэдээлэл хүргэдэг. Өмнөх туршлагаас

- Сургалт зохион байгуулахад амралтын өдрүүдээр зохион байгуулах
- Сургалтад олон хүмүүсийг хамруулахын тулд сургалтын хугацаа нь 1 цагаас хэтрэхгүй байх
- Сургалтыг сургуулийн сурагчдын хичээл тарах, цэцэрлэг тарах үер зохион байгуулах нь үр дүнгүй болдог.
- Сургалтад оролцсон өрхүүдийг бүртгэнэ

Олон нийтийн сургалтыг амралтын өдрөөр хорооны байранд зохион байгуулбал илүү үр дүнтэй болдог. Иргэд гэрийн ойролцоо байрлах хороон дээр бүгд ирэх боломжтой бөгөөд байршлыг нь мэдэж байдаг. Амралтын өдрөөр сургууль, цэцэрлэгийн хүүхдүүд амардаг ажилтай хүмүүс мөн гэртээ байдаг тул сургалтад оролцох нь сонирхолтой байдаг. Мөн олон нийтийн сургалтыг дээд тал нь хоёр цагийн хугацаанд багтаан мэдээлээ өгөх нь зүйтэй. Хэт урт сунжирсан байх нь иргэдийн сонирхол идэвхийг бууруулах магадлалтай байдаг.



Сургагч багш

Аяны сургагч багш нь Хялбар шийдэл аяны сургагч багш бэлтгэх хоёр өдрийн сургалтад хамрагдсан байна. Сургалтад хамрагдсанаар хороон дээр олон нийтийн сургалтыг хэрхэн зохион байгуулж ямар төрлийн мэдээлэл өгөх талаар мэдлэг олж авахаас гадна Хялбар шийдэл аяны сургагч багшийн гарын авлагыг хүлээн авна. Энэхүү сургагч багш бэлтгэх гарын авлага нь хэрхэн сургалт зохион байгуулах талаар болон сургагч багшид шаардлагатай бүх мэдээллийг багтаасан юм. Сургалт зохион байгуулахаас өмнө хамтран сургалт зохион байгуулах сайн дурын идэвхтэнтэй хэрхэн сургалт зохион байгуулах талаар ярилцаж тохирно. Сургалтын үеэр хэн хэн юу хариуцах уу гэх мэт.

Сургалтын үед судалгаа мэдээлэл өрхүүдээс авдаг тул сайн дурын идэвхтэнтэй энэ талаар урьдчилан тохиролцсоноор цаг хэмнэх ач холбогдолтой байдаг. Олон нийтийн сургалтын дараа сургагч өрх болох хүсэлтэй иргэдийг бүртгэж, Хялбар дулаалгын гарын авлага өгнө.

Сургалтын ирцийн бүртгэл, сургалтын үеийн зураг, сургалтын тайлан зэргийг тухайн сургалтыг зохион байгуулсан сургагч багш, сайн дурын идэвхтэн нар хариуцан бэлтгэж гарын үсгээр батгаажуулна. Сургалтын тайлан нь бэлтгэсэн загварын дагуу бүх мэдээлэлийг багтаасан байна.

> ***Сонгинохайрхан дүүрэг Улаан загалмайн хорооны сургагч багш Б.Оюун:*** *Сонгинохайрхан дүүргийн улаан загалмайн хорооны сайн дурын идэвхтнээр 15 жил гаруй ажилласан. Хялбар шийдэл аяны үйл ажиллагааны хүрээнд сургагч багшаар бэлтгэгдэж олон нийтийн сургалтыг хороодууд дээр зохион байгуулсан. Хороотой ярилцаж тохиролцсоны дагуу сайн дурын идэвхтэнтэй хамтран хорооны байранд сургалтыг зохион байгууллаа. Хорооны зүгээс дэмжлэг сайтай ирц сайн байлаа. Сургалтаар өгч байгаа мэдээлэл нь иргэдэд хэрэгтэй нэн шаардлагатай мэдээлэл тул иргэд сэтгэгдэл өндөр байлаа.*

Сайн дурын идэвхтэн:



Сонгогдсон иргэний нийгмийн байгууллага сайн дурын идэвхтнүүдийг хариуцан ажилладаг. Сайн дурын идэвхтэн нь

- Сургагч багштай хамтран олон нийтийн сургалт зохион байгуулана
- Сургагч өрхийн мэдээлэл, таван хөршийн зурагжуулалт хариуцан ажилладаг
- Сургач багшид шаардлагатай үед туслан дэмжлэг үзүүлж ажиллана
- Өдөрлөг, нээлттэй хаалганы өдөр зэрэг олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ

Сайн дурын идэвхтэн нь олон нийтийн сургалтын үеэр сургагч багшид тусалж сургалтын үеийг зурагжуулах нь маш чухал юм. Иргэдийн асууж буй асуултуудыг мөн тэмдэглэж авах хэрэгтэй бөгөөд ирц бүрдүүлэлт дээр мөн анхаарна.

Чингэлтэй дүүргийн Улаан Загалмайн хорооны сайн дурын идэвхитэн Э.Энхнаран: *Би уг төслийн сайн дурын идэвхтнээр Чингэлтэй дүүргийн 13 дугаар хороонд ажилласан. Тус сургалтыг сургагч багш С.Өнөр эгч маань их сонирхолтой, ойлгомжтой явуулсан нь иргэдэд мэдээлэл маш сайн хүрсэн. Тус хорооны иргэдийн хувьд их идэвхтэй байж, олон эрэг өөрчлөлтүүд гарсан. Төслийн дараа айл өрхөөс мэдээлэл авч, зурагжуулалт хариуцан ажилласан. Иргэдийн зүгээс дахин аян хэрэгжих үү, оролцоор байна гэсэн сэтгэгдэл ирж байсан. Иргэд аяны талаарх ойлголт, хандлага сайн байсан учраас миний хувьд төслийн явц хялбар байсан.*

Сургалтын тайлан:

Сургагч багш гарын авлагыг ашиглан сургалт хэрхэн зохион байгуулсан талаар загварын дагуу тайланг бэлтгэнэ.

- Сургалт зохион байгуулсан байршил, хаяг, хороо
- Сургалтын үеийн мэдээлэл
- Сургалтын үеийн зураг /сургагч багш хичээл зааж байгаа, оролцогчдын, бүлгийн ажлын үеийн гэх мэт үйл ажиллагаа харуулсан байна./
- Сургалтын өмнөх болон сүүлд санал асуулга авсан бол үр дүнг дурдах
- Сургалтын ирцийн бүртгэл хавсаргах

Сургалтын тайлан нь шаардлагатай мэдээллийг багтаасан байх тул нэгдсэн загвартай байх нь зүйтэй. Хэрэв олон сургагч багш ажиллах бол мэдээллийн зөрүүтэй тайлан, шаардлагагүй мэдээлэл, шаардлага хангаагүй зураг хавсаргасан байх магадлалтай тул аяныг хэрэгжүүлэгч нар сургагч багш сургалт зохион байгуулсан талаарх тайланд ямар мэдээлэл багтсан байх шаардлагатай талаар загвар гарган түүний дагуу тайлангаа хүлээн авах нь цаг хэмнэх давуу талтай.



БҮЛЭГ

4 Сургагч өрхтэй хамтран ажиллах





Сургагч өрхүүд хөршдөө мэдээлэл хүргэх

Олон нийтийн сургалтад хамрагдаж “Дулаалгын хялбар шийдлүүд” гарын авлагыг ашиглаж өөрийн таван хөршөө байшингаа дулаалахад уриалах, мэдээлэл хүргэх, идэвхжүүлэх өрхийг хэлнэ. Сургагч өрх нь өөрийн сайн дураар сонгогдоно. Сургагч өрх болохоор шийдсэн өрх бүртгэлийн хуудсанд бүртгүүлнэ “Дулаалгын хялбар шийдлүүд” гарын авлагыг хүлээн авна. Үүний дараа таван хөршдөө “Дулаалгын хялбар шийдлүүд” гарын авлагыг ашиглан хэрхэн байшин сууцаа хялбар аргаар дулаалж болох вэ гэдэг талаар мэдээлэл хүргэж, байшин сууцаа дулаалахад нь тусалж, зааж зөвлөнө. Сургагч өрх нь таван хөршийн Хялбар аргаар байшингаа дулаалсан аргыг зургаар баталгаажуулан сайн дурын идэвхтэнд илгээнэ. Ингэснээр сургагч өрх 5 см-ийн дээврийн дулаалга хүлээн авах эрхтэй болох юм



Бүлэг 4 **Сургагч өрхтэй хамтран ажиллах**

Сургагч өрх нь олон нийт дундаас өөрсдийнх нь хүсэл сонирхлын дагуу сонгогддог учир оролцоо сайтай байдаг. Иргэд өөрсдийн хөршөөс шинэ мэдээ мэдээлэл хүлээн авах нь илүү ур дүнтэй хүртээмжтэй юм. Зарим тохиолдолд сургагч өрхөөр ажиллах сонирхолтой иргэд бүртгүүлсэнийхээ дараа буцах тохиолдол мөн гардаг. Хэрэв тийм тохиолдолд тухайн өрх ямар шалтгааны улмаас сургагч өрх болохоос татгалзсан талаар тодруулан лавлаж дараагийн үйл ажиллагаандаа тэрхүү бэрхшээлийг хэрхэн даван туулах талаар мэдээлэл өгвөл иргэдийн оролцоо нэмэгдэх магадлалтай байдаг.

> *Манай байшин 50мкв талбайтай, Хялбар шийдлийн дулаалгын аргаар цонх, яндан, хаалгаа дулаалсан. Мөн "Сургагч өрх" болж таван хөршдөө мэдээлэл хүргэж цонх, хаалга зэргийг нь дулаалуулж зургаар баталгаажуулан СДИ-д илгээгээд дээврийн дулаалга авсан. Дулаалгын ур дүн илт мэдрэгдсэн. Өдөрт 2 шуудай нүүрс хэрэглэдэг байсан бол 1 шуудай болж багассан. Гэр дулаахан болохоор их тухтай, цэвэрлэгээ хийхэд ураматай, ариун цэвэр талаасаа их ахиц гарсан. Хүүхдүүд маань энэ өвөл ханиад хүрээгүй. Эдийн засгийн хувьд бид их хэмнэлт хийсэн, хэмнэсэн мөнгөөрөө бид өөрсдийгөө урамшуулж шарах шүүгээ худалдан авсан. Яндангаа дулаалснаар хажуу талаараа ус орж, ханан пийшингийн шавар нурах нь зогссон.* ***/Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны тоот иргэн Хувцагааны Болормаа/***

Сошиалаар олон нийтэд мэдээлэл хүргэх

Төслийн үйл ажиллагааны хүрээнд Хялбар шийдэл аяныг олон нийтэд хүртээмжтэй, олон хүнийг хамруулахын тулд олон нийтийн сүлжээг ашиглаж групп байгуулан мэдээлэл хүргэж ажилласан. Хэрэв олон нийтийн сувгийг ашиглан идэвхжүүлэлт хийхээр бол дараах алхмуудыг баримтлан ажиллана. Олон нийтийн сургалт, өдөрлөг зохион байгуулахдаа сошиал хаяг мэдээллээ хүргэнэ нэгдэхийг уриална.

АЛХАМ:
1

Фейсбүүк пэйжид нэгдэх

Аянд оролцох таны хамгийн эхний алхам бол Дулаан шийдэл төсөл, Хялбар шийдэл аян фейсбүүк пэйжид нэгдэх юм. Бид аяны талаарх бүх мэдээллийг энэхүү пэйж хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэдэг тул та цаг алдалгүй шинэ мэдээ мэдээллийг авах боломжтой.

АЛХАМ:
2

Сургалтад хамрагдах

Дараагийн алхам бол олон нийтэд зориулсан хялбар аргаар дулаалга хийж сурах сургалтад хамрагдаж, гарын авлага авна. Гарын авлагатайгаа сайтар танилцана.

АЛХАМ:

3

Өөрөө хэрэгжүүлэх

Гарын авлагыг ашиглан өөрийн гэртээ Хялбар шийдлүүдийг хэрэгжүүлж дулаан алдагдлыг бууруулна.



Таван хөршид Хялбар аргаар дулаалга хийж хэрэгжүүлэх


Гарын авлагыг ашиглан өөрийн таван хөрш, найз нөхөд, танилууддаа хэрхэн хялбар аргаар байшингаа дулаалах талаар мэдээлэл хүргэж, дулаалга хийх аргыг зааж өгөх, зарим аргуудаас хамтран хэрэгжүүлж, өөрсдийн байшин сууцны дулаан алдагдлыг бууруулахад нь дэмжлэг үзүүлэх. Энэ үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцож хэрэгжүүлсэн талаарх тайлан мэдээллээ зургийн хамт хариуцан ажиллаж байгаа СДИ-д ирүүлж баталгаажуулна. Ингэснээр та “Сургагч өрх ” болох боломжтой.

Сургагч өрх болсноор төслийн зүгээс авч хэрэгжүүлж байгаа 5см-ийн дээврийн дулаалга хүлээн авах эрхтэй болно. Энэ нь тухайн өрхийн байшин сууцандаа дулаалга хийх сэдлийг төрүүлэх анхны алхам болж байлаа.

АЛХАМ:

4

Хавсралт 1. Албан бичгийн загвар



geres
ACTING FOR CLIMATE SOLIDARITY

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Жуулчны гудамж, Дельта тев 403 тоот
Утас: (+976) 95007392

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

Огноо_____2023.11.02_____№_____/2023____
Танай _____-ны №_____-т

ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ

Европын Холбооны Свич-Эшиа II хөтөлберийн санхүүжилттэй "Дулаан шийдэл" төслийн хүрээнд Хялбар шийдэл аяныг Танай байгууллагатай хамтран Сонгинохайрхан дүүрэгт агаарын бохирдлыг бууруулахад иргэдийн оролцоо, ялангуяа эмэгтэйчүүдийн манлайллыг нэмэгдүүлж, дулаалгын ач холбогдлын талаар олон нийтийн мэдлэг, хандлагыг сайжруулан, байшин сууцаа дулаалахад иргэдийг уриалан хамтран ажилладаг. Танай хамт олонд талархал илэрхийлье.

2023-2024 оны төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу "Хялбар шийдэл" аяны хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 2 хорооны 25 эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрхөд дээврийн дулаалга хийх үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж байна. Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэх 2 хороог сонгож, бидний ажилд дэмжлэг үзүүлнэ үү
/Саналаа 2022 оны 11 дүгээр сарын 07-ны дотор n.gayasuren@geres.eu хаягаар ирүүлнэ үү/

Хүндэтгэсэн,

Элиан Жарри
Суурин Төлөөлөгч
Дулаан шийдэл төслийн менежер

Хавсралт 2. Санамж бичиг загвар

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ

202… оны ….дүгээр сарын … өдөр Дугаар Улаанбаатар хот

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү санамж бичгийн зорилго нь ……хөтөлбөрийн дэмжлэгтэй …… төслийг …… дүүрэгт хэрэгжүүлэхэд хамтран ажиллах юм. Энэхүү гурван талт санамж бичгийг нэг талаас …… дүүргийн Засаг дарга……(цаашид Засаг дарга гэх), нөгөө талаас дэмжлэгтэй ……удирдан хэрэгжүүлэгч …… төлөөлөх, суурин төлөөлөгч……., төслийг хамтран хэрэгжүүлэгч ……төлөөлөх захирал …… (цаашид Төслийн баг гэх) нар (цаашид "талууд" гэх) дараах нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. ……нь 202….-202…..онд хэрэгжих бөгөөд Монгол Улсын бариглын салбарт байгальд эзлэгдэй эрчим хүчний хэмнэлттэй, хүлэмжийн хий ялгарал багатай туршлагыг нэвтрүүлэх зорилгоор иргэдэд хүртээмжтэй, тохиромжтой шийдлүүдийг хөгжүүлж, хувийн байшин суурьны эрчим хүчний хэмнэлттийг нэмэгдүүлж, түлшний хэрэглээ, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зах зээлийг бий болгох зорилготой. Төслийг хэрэгжүүлэх хүрээнд Талууд доорх үйл ажиллагаанд хамтран зохион байгуулна.

1.1.1. Байшин суурьны дулаан алдагдлыг бууруулах чиглэлээр иргэдийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлж, сургалт сурталчилгааны аян зохион байгуулна.

1.1.2. Гарын доорх материалаар байшинтаа дулаалах "Хялбар шийдэл" аяныг хэрэгжүүлэхээр сонгогдсон …… дүүргийн зорилтот хороодын айл өрхүүдийн байшин суурьны дулаан алдагдлыг бууруулах чиглэлээр хамтран ажиллана.

1.1.3. Төслийн хүрээнд зохион байгуулагдах албан ёсны хурал, уулзалт болон бусад үйл ажиллагаанд талууд харилцан тохиролцсоны дагуу идэвхтэй оролцоно.

1.2. Талуудын хамтын ажиллагаа нь хуулийг дээдлэх, ил тод, нээлттэй, үр ашигтай/дүнтэй, харилцан бие биеэ хүндэтгэх зарчимд суурилна.

ХОЁР. ТАЛУУДЫН ОРОЛЦОХ ХЭЛБЭР

2.1. **Засаг дарга**

2.1.1. Дүүргийн Засаг даргаас Засаг даргын Тамгын газрын Ахлахын бохирдлыг бууруулах чиглэлийг хариуцсан нэгжээс Төслийн багтай хамтран ажиллах албан тушаалтныг томилно.

2.1.2. Төслийн тогтвортой байдал, үр дүнтэй хэрэгжилтийн хүрээнд үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, сургалт сурталчилгааны аян хамтран зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

2.1.3. Жил бүр уламжлал болон зохион байгуулагдаг " Өвөлжилтийн бэлтгэл" ажлын хүрээнд зохион байгуулагдах өдөрлөг, сургалт, олон нийтийг чиглэсэн үйл ажиллагаанд Дулаан шийдэл 2 төслийг хамтран хэрэгжүүлэгчидтэй хамтран зохион байгуулна.

2.1.4. "Хялбар шийдэл" аянд хамрагдахаар сонгогдсон хороодын дарга нарт, мөн тухайн хороодын нутаг дэвсгэрт харъяалагддаг сургууль, цэцэрлэгүүдийн удирдлагуудад Дулаан шийдэл II төслийн талаарх шаардлагатай мэдээллүүдийг дамжуулан хүргэнэ.

2.1.5. "Хялбар шийдэл" аяныг хэрэгжүүлэхэд шаардлагатай статистик тоон мэдээлэл болон бусад шаардлагатай мэдээллээр төслийн багийг ханган.

2.1.6. Төслийн хэрэгжүүлэх явцад бий болсон шинэ мэдлэг, туршлагыг нийслэлийн бусад дүүргүүд гэр хорооллод амьдардаг айл өрхүүдэд хүргэх, мэдээ мэдээллийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор сурталчилгааны ажлыг талууд харилцан тохиролцож хамтран зохион байгуулж болно.

2.2. **Жэрэс ОУТББ:**

2.2.1. "Дулаан шийдэл II" төслийг хамтран хэрэгжүүлж буй байгууллагуудыг ерөнхий зохицуулалт, төслийн үр дүнтэй менежментээр ханган ажиллана.

2.2.2. Эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүдийг олон нийтэд таниулах, сурталчлах, санал болгох замаар зах зээлийн системийг хөгжүүлнэ.

2.2.3. Олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгааны аяныг зохион байгуулна.

2.2.4. Байшин суурьны дулаан алдагдлыг багасгах тохиромжтой аргуудаас туршиж, сонгосон өрх айлуудад оновчтой шийдлүүдийг зөвлөж, гарын авлага, шаардлагатай сургалтын материалаар ханган.

2.2.5. Төслийн зүгээс одоо хэрэгжиж байгаа, мөн цаашид хэрэгжих үйл ажиллагааны мэдээлэл, тайланг хамтрагч талууд болон иргэдэд тухай бүр хүргэж ажиллана.

2.3. **…… ТББ:**

2.3.1. …… (……..) "Хялбар шийдэл" аяныг ……..дүүргийн сонгогдсон хороодын айл өрхүүдийн дунд хэрэгжүүлнэ.

2.3.2. Улаанбаатар хотын гэр хорооллын хувийн суурьт зөв дулаалах дадлыг иргэдэд бий болгох зорилгоор мэдээ мэдээллэл хүргэж, иргэд, олон нийт, Хороо, хэсгийн ахлагч, сайн дурын идэвхтэнүүдэд сургалт зохион байгуулна.

2.3.3. Улаанбаатар хотын гэр хорооллын иргэдийн дунд эрчим хүчний хэмнэлттэй хувийн суурьт зөв дулаалах дадлыг бий болгох хэрэгээр төслийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллана.

2.3.4. "Хялбар шийдэл" аяныг олон нийтийн оролцоог ханган ажилладаг ИНБ-тай хамтран хэрэгжүүлнэ.

2.3.5. Төсөл хэрэгжих хугацаанд үйл ажиллагаатай холбоотой хэрэгжилтийн тайлан мэдээг тогтсон хугацаанд талуудад мэдээлнэ.

2.3.6. Төслийн үйл ажиллагааны сайн туршлагыг олон нийтэд сурталчилна.

ГУРАВ.БУСАД ЗҮЙЛ

3.1. Энэхүү санамж бичиг нь талууд гарын үсэг зурж, баталгаажуулсан өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

3.2. Талууд жил бүр санамж бичгийг дүгнэн, төсөл хэрэгжих 4 жилийн хугацаанд хамтран ажиллах нөхцлийг харилцан тохиролцсоны үндсэн дээр сунгаж болно.

3.3. Хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд солилцсон мэдээлэл, статистик тоон мэдээллийг талууд зөвхөн төслийн хүрээнд ашиглана.

3.4. "Санамж бичиг"-ийн талаар харилцан тухай бүр мэдээлэл солилцож, хууль зүйн үндэслэлээр тодорхой шаардлага үүсвэл харилцан зөвлөлдөх замаар санамж бичигт нэмэлт өөрчлөлт оруулж болно.

3.5. Санамж бичгийн хэрэгжилтийн хугацаанд талууд хамтын ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон гэж үзвэл энэ тухай албан бичгээр мэдэгдэж, цуцалж болно.

3.6. Тус Санамж бичгийг 2024 оны 4 дүгээр сарын 17-ний өдөр Улаанбаатар хотод Монгол, Англи хэл дээр тус бүр 2 хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд хуулийн хувьд адил хүчин төгөлдөр байна.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:

…… Дүүргийн Засаг Дарга …….. ОУТББ-ын Суурин Төлөөлөгч ……ТББ-ын Гүйцэтгэх Захирал

Хавсралт 3: Иргэний гийгмийн байгууллага
сонгон шалгаруулах зар

БИДЭНТЭЙ НЭГДЭЭРЭЙ: 202.... ОНЫ ХЯЛБАР ШИЙДЭЛ АЯНЫГ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГА ХАЙЖ БАЙНА

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

.Энэхүү төсөл нь гэр хороолол дахь хувийн орон сууцны эрчим хүчний хэмнэлттийг нэмэгдүүлэн түлшний хэмнэлттийг бий болгох замаар агаарын бохирдлыг бууруулах зорилготой юм. Төслийн хүрээнд МОНЭС нь олон нийтэд дулаалгын ач холбогдлын таниулах, байшин сууцныхаа эрчим хүчний хэмнэлттийг сайжруулахад уриалах зорилготой "Хялбар шийдэл" аяныг хэрэгжүүлж байна.

ЗОРИЛГО:

.....дүүргийн сонгогдсон хороодод "Хялбар шийдэл 202..." аяныг хамтран хэрэгжүүлэх иргэний нийгмийн байгууллагыг (ИНБ) хайж байна. Хамтран ажиллах ИНБ нь аяныг хэрэгжүүлэхэд олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаанд голлох үүргийг гүйцэтгэх бөгөөд оролцогч талуудын хамтын ажиллагааны уялдааг хангаж, аянд оролцож буй өрхүүдийг чиглүүлэн, сургалт зохион байгуулах, дэзверийн дулаалгын материал түгээлт зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Мөн логистикийн дэмжлэг үзүүлэн ажиллана.

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

Хамтран ажиллах ИНБ-д дараах шаардлага тавигдана.

- Идэвхитэй, туушгай ажилладаг сайн дурын идэвхтний багтай байх
- **Эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжин ажилладаг байх /Эмэгтэй удирдагчтай бол давуу тал болно/**
- Гэр хороололын бүсэд ажиллаж байсан туршлагатай байх
- Сүүлийн жилүүдэд олон нийтийн оролцооны чиглэлээр идэвхитэй үйл ажиллагаа явуулсан туршлагатай байх
- Зориптот дүүрэг, хороодын удирдлага болон иргэдтэй холбоо, харилцаа сайтай байх дадлын зуршил өөрчлөлт болон жендэр хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулсан туршлагатай байх

ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Хамтын ажиллагаанд дараах үйл ажиллагаа хамаарна:

- Хороодын дэмжлэгтэйгээр аянд оролцох боломжтой өрхийн судалгааг гаргах
- Сургалтын зарыг айл өрхүүдэд мэдээллэж, сургалтанд идэвхитэй хамруулах
- Сургалтын логистикийн бэлтгэл хангаж, олон нийтийн сүлжээнд мэдээлэл түгээх
- Оролцогчдыг сургалтын дараах мэдээллээр хангаж аянд оролцох боломжийг танилцуулах
- Дэзверийн дулаалга хийхэд бэлтгэл хангагдсан эсэхийг шалгах
- Дэзверийн дулаалгын материал түгээлтийг хариуцан ажиллах

ӨРГӨДӨЛ ГАРГАХ:

Сонирхсон бүх байгууллагыг хамтран ажиллах хүсэлт гаргахыг урьж байна. Өргөдлийн маягтыг энэ холбоосоор орж бөглөн 202. Оны...-р сарын ..-ны дотор ирүүлнэ үү.

ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ЦЭВЭР АГААР, НОГООН ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨХ ЭРХЭМ ЗОРИЛГОД БИДЭНТЭЙ НЭГДЭЭРЭЙ!

Хавсралт 4: Тайлангийн загвар

ДУЛААЛГЫН ХЯЛБАР ШИЙДЭЛ АЯН
СУРГАЛТЫН ТАЙЛАН
(.....ДҮҮРГИЙН .....ХОРОО)



Улаанбаатар
202...

“Дулаалгын хялбар шийдэл аян”-ны сургалтын тайлан

Сургалтын зорилго:

Сургалтын агуулга:

Сургалт заасан багийн бүрэлдэхүүн:

Сургалтанд оролцогчдын тойм мэдээлэл:

Сургалтын гол мессеж, мэдээлэл:

Сургалтын үнэлгээний үр дүн:

Оролцогчдын санал сэтгэгдэл:

Сургалтын талаарх мэдээлэл хороодоор:

№	Хороо	Иргэд, олон нийтийн санал сэтгэгдэл
1	.....хороо	
2	..... хороо	
3	..... хороо	
4	..... хороо	

Сургалтын дүгнэлт:


ХАВСРАЛТ 1. Оролцогчдын ирцийн мэдээлэл:


ХАВСРАЛТ 2. Сургалтын зургаас

Тайлан бичсэн: ...../ /

Хавсралт 5: Олон нийтийн сургалтын танилцуулга.
















БАЙГАЛЬ ОРЧИН
ЭРҮҮЛ МЭНД


ДУЛААН АЛДАЖ БУЙГ ЯАЖ МЭДЭХ ВЭ?
1 ЦАНТАЛТ
ЦОНХ БОЛОН ХААЛГА ХЭСГЭЭР ЦАН ЦОХИХ
2 МӨСТӨЛТ
ХААЛГА, ЦОНХ БОЛОН ДЭЭВРЭЭС Мөс ТОГТОХ
3 ЧИЙГ
ЦОНХ ХААЛГА БОЛОН ХАНА Хаварч, ЧИЙГТЭХ
4 ХАР ТОЛБО
БАЙГУЛЬ ЧИЙГНЭЭС үүдэлтэй ХАР Мөөгөнцөр ХАНАНД үүсэх


ХАР МӨӨГӨНЦӨР ҮҮСЭХ ШАЛТГААН
ДУЛААН АЛДАГДАЛ
ЦАН ЦОХИХ
БАЙНГЫН ЧИЙГ
ХАР МӨӨГӨНЦӨР



ДУЛААН АЛДАГДАЛТАЙ БАЙШИНД АМЬДРАХ СӨРӨГ НӨЛӨӨ
Хор урших
1 АСТМА, АМЬСГАЛЫН ЗАМЫН ӨВЧЛӨЛ
2 ҮЕ МӨЧНИЙ ӨВЧЛӨЛ ҮРЭВСЭЛ
3 МӨӨГӨНЦРӨӨ С ҮҮДСЭН ХАРШИЛ, ЗАГАТНАА
4 ХАНИАД ТОМУУ, ХАЛДВАРТ ӨВЧИН


БАЙШИН АЛЬ ХЭСГЭЭР ХЭР ИХ ДУЛААН АЛДДАГ ВЭ?
Хана 34%
Суурь 6%
Дээвэр 32%
Цонх 10%
Үлдсэн 18% ийг хаалга, агаажуулалтын систем болон дулааны гүүрээр алддаг байна.


ДУЛААЛГЫН ТӨРӨЛ
+50% ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ
СТАНДАРТ ДУЛААЛГА
ДУЛААЛГЫН ЗОРИУЛАЛТЫН МАТЕРИАЛ АШИГЛАН, МЭРГЭЖЛИЙН ТЕХНОЛОГИЙН ДАГУУ ДУЛААЛАХЫГ ХЭЛНЭ. ҮҮНД:
ДЭЭВЭР- 20 СМ
ХАНА- 15 СМ
СУУРЬ
АГААРЖУУЛАЛТ
ЦОНХ САЙЖРУУЛАЛТ
16% ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ
ХЯЛБАР ДУЛААЛГА
ГАРЫН ДООРХ МАТЕРИАЛ АШИГЛАН, ХЯЛБАР АРГААР ДУЛААЛАХЫГ ХЭЛНЭ. ҮҮНД:
ЦОНХ
ХААЛГА
ШАЛ
ЯНДАН
ХАНА

Хавсралт 5: Олон нийтийн сургалтын танилцуулга.













ӨНГӨ ҮЗЭМЖ
СТАНДАРТ ДУЛААЛГА ХИЙСНЭЭР БАЙШИНГИЙН ӨНГӨ ҮЗЭМЖ САЙЖИРНА.

ТАВ ТУХ
ГЭРТЭЭ ДААРЧ **ХӨРӨХ** НЬ БАГАССАНААР ТАВ ТУХ НЭМЭГДЭНЭ.

ҮНЭЛЭМЖ ӨСНӨ
СТАНДАРТ ДУЛААЛГА ХИЙСНЭЭР БАЙШИНГИЙН НАСЖИЛТ УРТСАЖ, ҮЛ ХАДЛАХ ХӨРӨНГИЙН ҮНЭЛЭМЖ ӨСНӨ.

ЭДИЙН ЗАСГИЙН ХЭМНЭЛТ
ТҮЛШ, ЦАХИЛГААНЫ ХЭРЭГЛЭЭ БУУРЧ ЗАРДАЛ БАГАСНА. ХАНИАД ТОМУУНЫ ЭМНИЛГЭЭНД ЗАРЦУУЛАХ МӨНГӨ ХЭМНЭНЭ.

БОГИНО ХУГАЦААНД, БАГА ЗАРДЛААР
ГАРЫН ДООРХ, ОЛДООЦ САЙТАЙ, ХЯМД МАТЕРИАЛААР БАЙШИНГАА ХЯЛБАР АРГААР ДУЛААЛСНААР БОГИНО ХУГАЦААНД ҮР ДҮН МЭДЭРНЭ


ЭРҮҮЛ МЭНД
ДОТОР АГААРЫН ЧАНАР САЙЖИРЧ, ЭРҮҮЛ МЭНДЭД ЭЕРЭГЭЭР **НӨЛӨӨЛӨНӨ**. БАГА НАСНЫ **ХҮҮХДИЙН** ХАНИАД ТОМУУ ТУСАХ НЬ БАГАСНА.



БАГИЙН АЖИЛ

15 МИН

ЦОНХЫГ ЯМАР МАТЕРИАЛААР ДУЛААЛСАН БЭ?



10%

ЦОНХ

ЦОНХОНД ИХ ТОО БИШ ГЭЖ ҮҮ? САЙН ДУЛААЛААГҮЙ. СИЙГЭЛТ ИХТЭЙ ЦОНХ ҮҮНЭЭС Ч ИХИЙГ АЛДДАГ. **МӨН** ОЛОН ЦОНХТОЙ БАЙХ ТУСМАА ЭНЭ ТОО НЭМЭГДЭНЭ. ТИЙМЭЭС ЦОНХЫГ САЙТАР ДУЛААЛЖ БАЙХ ХЭРЭГТЭЙ.

ХААЛГЫГ ЯМАР МАТЕРИАЛААР ДУЛААЛСАН БЭ?




8%


ХААЛГА

ХААЛТТАЙ ХААЛГА Ч ДУЛААН АЛДДАГ ГЭДГИЙГ ТА МЭДЭХ ҮҮ? ЭНЭ ТОО ОРЖ ГАРАХ **БҮРТ** НЭМЭГДЭНЭ ГЭХЭЭР ХААЛГЫГ ЗАЙЛШГҮЙ ДУЛААЛАХ ХЭРЭГТЭЙ ЮМ.


Хавсралт 5: Олон нийтийн сургалтын танилцуулга.

























ТА ХЯЛБАР АРГААР ГЭРЭЭ ДУЛААЛАХ УУ?


ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?
1000 АЙЛ
БАЙШИНГАА ДУЛААЛЖ,
20%-ИАР
ДУЛААН АЛДАГДЛЫГ БУУРУУЛБАЛ
1600 ТОНН
НҮҮРС ТҮЛЭХЭЭС СЭРГИЙЛЖ
6000 ТОНН
НҮҮРСХҮЧЛИЙН ХИЙ АГААРТ ДЭГДЭХЭЭС СЭРГИЙЛНЭ.



ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?
1000 АЙЛ
БАЙШИНГАА ДУЛААЛАХ
1000 ГЭДЭГ БАГА ТОО Ч ГЭСЭН...
ДАЛАЙ ДУСЛААС ЭХЭЛДЭГ

Хавсралт 5: Олон нийтийн сургалтын танилцуулга.














7505-2000

“ДУЛААН ШИЙДЭЛ ТӨСӨЛ”

dulaanshiideltusul@gmail.com